

## АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

**Байршил:** Налайх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

**Эхлэх хугацаа:** 2024/12/25

**Дуусах хугацаа:** 2025/01/25

**Ажил эхлэх хугацаа:** 2025/01

**Цалин:** Боловсрол, ажлын туршлагыг харгалзана.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2013 он байгуулагдсан Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль нь Монгол Улсын төрийн өмчит дээд боловсролын байгууллага юм. Тус сургууль нь Монгол Улсын болон ХБНГУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

## СИСТЕМ ХӨГЖҮҮЛЭЛТИЙН МЭРГЭЖИЛТЭН

### *Гүйцэтгэх үндсэн чиг үүрэг:*

- Ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргүүдийг гүйцэтгэх
- Байгууллагын системийн хэвийн ажиллагааг хариуцаж ажиллах
- Дотоод үйл ажиллагаанд шаардлагатай программ хангамж болон системийг хөгжүүлэх

### *Тавигдах шаардлага:*

- Программ хангамж, Мэдээллийн систем, Мэдээллийн технологи чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх
- Программ хангамж, систем хөгжүүлэлт, веб хөгжүүлэлтийн чиглэлээр 2 болон түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх
- PHP, Java, MySQL, MS SQL, JavaScript, REST API технологиуд дээр ажиллаж байсан туршлагатай байх
- Серверийн орчинд ажилладаг байх
- Next JS, React, React Native дээр туршлагатай бол давуу тал болно
- Англи хэлний B1 болон түүнээс дээш түвшний мэдлэгтэй байх
- Багаар болон бие даан ажиллах чадвартай байх.

### *Бүрдүүлэх материал:*

- Ажилд орох өргөдөл
- Товч намтар
- Мэргэжлийн ур чадварыг тодорхойлсон диплом, сертификат болон батламжийн хуулбар
- Өөрийн хөгжүүлэлт хийж байсан бүтээлүүдийн жагсаалт
- Өмнөх ажил олгогчийн тодорхойлох захиа – 2 хувь

### *Холбоо барих:*

Та баримт бичгээ англи эсвэл монгол хэл дээр бэлтгэн 1 PDF файл болгон эмхэтгэж [recruitment@gmit.edu.mn](mailto:recruitment@gmit.edu.mn) хаягаар бидэнд ирүүлнэ үү.

**Цахим хуудас:** [www.gmit.edu.mn](http://www.gmit.edu.mn)

Бидэнтэй +976 7023-2090 тоот утсаар болон цахим хаягаар холбогдох боломжтой.

**Жич:** Зөвхөн шаардлага хангасан ажил горилогчидтой эргэн холбогдож ажлын ярилцлагад урих болно.